



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 28

Дугаар 14/12

Баян-Өндөр сум

Г

Т

Хороодын даргыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Хурлын хорооны үйл ажиллагааны журам”-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны даргаар Сүхбаатарын Юмэнхүү, Нийгмийн хөгжлийн хорооны даргаар Хандрагчаагийн Төгсбаяр, Эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийн хорооны даргаар Сайнбилэгийн Ганцогт, Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны даргаар Гомбонасангийн Эрдэнэбат, Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны даргаар Дашзэвэгийн Энхзориг, Дэд бүтэц, хот байгуулалт, гэр хорооллын хөгжлийн хорооны даргаар Цагаанцоожийн Алтаншагай, Цахим бодлогын хөгжлийн хорооны даргаар Эрдэнэчимэгийн Батжаргал, Ёс зүйн хорооны даргаар Пүрэвжавын Пүрэвлхагва нарыг тус тус баталсугай.

2. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 55 дугаар зүйл, Хурлын хорооны үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг тус тус ханган ажиллахыг Хурлын хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д. МӨНХБАТ

